

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

ИЛТГЭХ ХУУДАС

Монгол-Оросын хамтарсан Хэнтий аймгийн Баян-Адарга, Төв аймгийн
Мөнгөнморьт сумын тарваган тахлын цурав голомтын
эпизоотологийн судалгаа

2024 оны 06 дугаар сарын 21

Багануур дүүрэг

Нэг. Үндэслэл:

Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэр нь Хэнтийн дэрлэгүүн, Мөнгөн-Хэрлэнгийн цурав голомтонд хамрагддаг. Тус цурав голомт нь Гурван-Байдлаг, Тэрэлж-Номгон, Тэнүүн-Зоргол, Баруунбүрх-Тосон, Моностой гэсэн 5 өр голомтонд хуваагддаг. Тус голомтот нутаг нь зүүн талаараа Цэнхэрийн цурав голомтонд хамрагдах Тэнхлэгийн өр голомт, Баянзүрхийн өр голомттой, Баруун урд талаар Туулын цурав голомттой хил залгадаг. Тэнүүн-Зорголын өр голомтонд /Хойд хориуд, Их өвөлжөө/ 1952 онд, Цохионы талд 1953, 1954 онд, Номгонд 1992 онд тарваган тахлын хүний өвчлөл гарч байсан. 1957, 1958, 1959, 1969 онуудад шимэгчгүйтгэл хийж байсан. Энэ голомтонд /Мөнгөн-Хэрлэнгийн цурав/ 1983 оноос эхлэн тус НЗӨСТөвөөс тарваган тахлын Байгалийн голомт хяналтын шинжилгээ хийж ирсэн. Төв аймгийн Мөнгөнморьт суманд 2020 онд хийсэн тандалт шинжилгээ, судалгаагаар 2 эерэг сорьц гарсан нь ЗӨСҮТ-ийн Лавлагаа лабораториор баталгаажаагүй боловч Төв аймгийн Мөнгөнморьт суманд тарваган тахал өвчний байгалийн голомт дахин сэргэх боломжтой байгаа тул тухайн сумын нутаг дэвсгэрт тарваган тахал өвчний байгалийн голомтыг хянах, хайгуул судалгааг хийх шаардлагатай байна.

Хоёр. Судалгааны арга зүй:

2.1. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу ОХУ-ын Эрхүү хот, Чита мужын Тарваган тахал эсэргүүцэн судлах станц, Хэнтий аймгийн ЗӨСТ-тэй хамтран тарваган тахлын тандалт судалгаан зохион байгуулж ажиллалаа. Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэрийг хамруулан тарваган тахал, түүнтэй хам тохиолдох өвчний байгалийн голомт хяналтын тандалт, хайгуул, шинжилгээг ЗӨСҮТ-ийн Захирлын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/07 тушаалаар баталсан "Тарваган тахал түүнтэй хам тохиолдох халдварт өвчний байгалийн голомтын тандалт судалгааны заавар"-ыг баримтлан 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 16-ний өдрийг дуустал 6 хоногийн хугацаанд Амьтан судлагч Б.Учрахбаяр, Халдвар судлагч эмч Б.Наранхүү, Шимэгч судлагч Б.Мөнгөнбагана, Бэлтгэмэлчин Т.Тунгалаг, Жолооч М.Баярсайхан, нар хамтран хийж гүйцэтгэлээ.

Гурав. Хийж гүйцэтгэсэн ажил:

3.1. Амьтан судлал:

3.1.1. НЗӨСТ-ийн судалгааны баг Төв аймгийн Мөнгөнморьт сумын 3 сектор, 27,000 га талбайд Тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний байгалийн голомт хяналтын тандалт, хайгуул шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

3.1.2. Судалгаагаар нийт 45 амьтан олзворлосон. Урт сүүлт зурам *Citellus undulatus* 40, Монгол тарвага *Marmota sibirica* 5 олзворлосон. Амьтан олзворлосон биотоп бүрт цаг уурын хэмжилт хийсэн.

3.1.3. 12 га талбайд маршрут, 2 га талбайд тэглэл, нийт 14 га талбайд агуулагчдын тооллого хийсэн.

3.1.4. Мэрэгчийн 150 нүх үзэж 1 бүүрэг, 45 амьтан самнаж 51 бүүрэг, 3 бөөс нийт 54 гадны шимэгч цуглуулан лабораторийн шинжилгээнд хамруулахаар болов.

3.1.5. Нийтийн хайгуулыг 6 удаа хийсэн. Хайгуулаар зэм үхтэл олзворлоогүй, махчин шувуудын 12 гулгидас цуглуулж лабораторит өгөв.

3.1.6. Араатан амьтан болон махчин шувууны тооллого 3 удаа хийхэд хярс үнэг 2, шар үнэг 1, махчин шувуу 26 тоологдсон.

2. Нян судлал:

Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэрээс олзворлосон 45 ОША-г задлан элэг, дэлүүнээс авч наац болон тэжээлт орчинд авч суулгасан. Цээжний хөндийн цуснаас мертолет натри шингээсэн цаасанд авч хатаан авчирсан.

НЗӨСТ-ийн лабораторит нян харах, нян судлал, биологи, молекул биологийн шинжилгээнд хамруулан ажиллаж байна.

Зураг 1.Шинжилгээний явцаас /2024.06 сар. Мөнгөнморьт сум/



Лабораторийн шинжилгээнд нийт ОША - 45, ГАШ-7 бүлгийг нян харах, нян судлал, биологи, молекул биологийн шинжилгээ үргэлжлэн хийгдэж байна.

3. Хүн амын тандалт судалгаа:

3.1. Тухайн нутгийн малчин өрхийн 30 иргэнээс асуумж судалгаа авч, байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний халдварлах зам, эмнэлзүйн талаар мэдээлэл өгч, санамж материал тараан ажилласан.

3.2. Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 14 эмч, мэргэжилтэнд 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Зоонозын халдварт өвчний талаар мэдээлэл, сургалт хийсэн.

3.3. Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хонгорзул, Дархлаажуулалт хариуцсан сувилагч Ц.Янжиндулам нарт ажлын удирдамж танилцуулж. Тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт, зөвлөн туслах үйлчилгээг, зөвлөгөө зааварчилгаа өгч ажилласан. Үүнд:

3.3.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдолд анхан шатны нэгж дээр анхны тусламжийг үзүүлж шархны цэгцлэлт хийж яаралтай галзуугийн эсрэг вакцинд хамруулахад сумын эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн сургалт мэргэшсэн байдал.

3.3.2. Галзуу өвчний эсрэг вакцины орлого, зарлага, устгал байгаа эсэх.

3.3.3. Дархлаажуулалтын ажлын байрны нөхцөл байдал, урсгал, тоног төхөөрөмжийн хүчин чадал, вакцин хадгалалт, хөргөгчний хэм, паспорт хөтлөлт.

3.3.4. Вакцин үйлдвэрлэгчийн заавар ойлгомжтой эсэх, бусад вакцинтай андуурахаас сэргийлэх талаар.

3.3.5. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу анхан шатны маягт хөтлөлт хийгдэж байгаа байдал.

3.3.6. Галзуу өвчний эсрэг вакцинд бүрэн тунд хамрагдсан байдал.

3.3.7. Эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд, болон иргэдэд галзуу өвчний эрсдэл, эрсдэлд өртсөн тохиолдолд вакцин бүрэн тунгаар хийлгэхийн ач холбогдолын талаар сургалт мэдээлэл хийсэн байдал.



ХЯНАСАН:
ХАЛДВАР СУДЛАГЧ ИХ ЭМЧ



ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ШИМЭГЧ СУДЛАГЧ



А.МӨНХТУУЛ

Б.МӨНГӨНБАГАНА